



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн зарим эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн барилга, байгууламж ашиглалтад орж, тусламж, үйлчилгээний хүрээ нэмэгдсэн, орны тоог орхигдуулсантай холбогдуулан орны дээд хязгаарт нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Улсын хэмжээнд 2015 онд ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тушаалын 1-4, 6, 7 дугаар хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсугай. Үүнд:

1.1 Хоёрдугаар хавсралтын Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн нийт орны тоог 500 болгон тусгай эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн ор бүхий төвүүдийн улсын төсвөөс санхүүжих бүгд орыг 1709 болгон өөрчлөх;

1.2 Гуравдугаар хавсралтын 21 аймаг дахь бусад салбарын харьяа тусгай эмнэлгүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 241 орыг хасч төсвөөс санхүүжих орны тоонд нэмж тусган, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нийт орны тоог 786, төсвөөс санхүүжих нийт орны тоог 415 болгон өөрчлөх;

1.3 Дөрөвдүгээр хавсралтын Сүхбаатар аймгийн төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын улсын төсвөөс санхүүжих орны тоог 34-өөр нэмж 196 болгон, 2015 онд ашиглах бүгд орны тоог 370 болгон өөрчилж, аймгуудын төрийн өмчит эмнэлгүүдийн улсын төсвөөс санхүүжих нийт орны тоог 4501 болгох, Завхан аймгийн хувийн өмчит сувиллын орны тоог 15 болгон өөрчилж хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагын нийт орны тоог 55 болгон нэмж, аймгийн хэмжээнд ашиглах бүгд орны тоог 458 болгон өөрчлөх;

1.4 Зургаадугаар хавсралтын Эрүүл мэнд, спортын яамны тусгай зөвшөөрөл бүхий хувийн өмчит эмнэлгүүдийн 2015 онд ашиглах орны дээд хязгаарыг Мон-мэс эмнэлгийн 50 орыг нэмж, хувийн өмчит эмнэлгүүдийн нийт орны тоог 1813 болгон өөрчлөх;

1.5 Долоодугаар хавсралтын Эрүүл мэнд, спортын яамны тусгай зөвшөөрөл бүхий сувиллын 2015 онд ашиглах ор Улаанбаатар төмөр замын “Булагтай” сувиллын


080263

орыг 40-өөр нэмж 100 болгон, сувиллын 2015 онд ашиглах нийт орны тоог 2545 болгон өөрчлөх;

1.6 Тушаалын хоёр, гурав, дөрөв, зургаа, долоодугаар хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтүүдтэй холбоотой нэгдүгээр хавсралтын улсын хэмжээний нийт орны тоог 26519, үүнээс төв эмнэлэг, тусгай мэргэжлийн ор бүхий төвийн бүгд орыг 4237, төсвөөс санхүүжих орыг 1709, тусгай эмнэлгүүдийн төсвөөс санхүүжих орыг 415, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орыг 786, орон нутгийн эмнэлэг, сувиллын нийт орыг 10978, төрийн өмчит эмнэлгийн төсвөөс санхүүжих орыг 4501, бүгд орны тоог 8524, хувийн өмчит сувиллын орны тоог 975, улсын хэмжээний үйлчилгээ үзүүлж буй хувийн өмчит эмнэлгийн бүгд орны тоог 1813, сувиллын бүгд орны тоог 2545 болгон нэмж, эмнэлэг, сувиллын нийт орны тоог 4358 болгон тус тус өөрчлөх.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбоотой “Улсын хэмжээнд 2015 онд ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тушаалын 1, 2, 3, 4, 6, 7 дугаар хавсралтуудад орсон өөрчлөлтийн хүрээнд орны зохицуулалт хийх нь улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, бууруулах үндэслэл болохгүйг анхаарч ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүх төрлийн өмчийн хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА